



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/584

Булган сум

**Гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 17 дугаар зүйлийн 17.1.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эрхийн зөрчлийн хэлбэрээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлын хүрээнд “Грийн бизнес өвнэр” ХХК-тай хамтран “Эж” төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, гэрээний хугацаа болон гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах эрхийг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д олгосугай.

2. Шаардагдах 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төсвөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



0323010030